Өлгий сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өлгий сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** БӨА-2024/135/НА-СТА-ТШЗ


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Өлгий хот<br>2024 он | Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл<br>Утас: 70422954 Цахим хаяг: aigulj@audit.gov.mn<br>Аудитын менежер: Х.Женисбек<br>Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn<br>Ахлах аудитор: У.Ербол<br>Утас: 99425121 Цахим хаяг: erbolu@audit.gov.mn |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Өлгий сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**АГУУЛГА**


1. Хараат бус аудиторын дүгнэлт ..........
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ..........
3. Санхүүгийн тайлангийн тодруулга ..........
   3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа ..........
   3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин ..........
   3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ..........
   3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт ..........
4. Аудитын тайлан ..........
   4.1 Ерөнхий зүйл ..........
   4.2 Материаллаг байдал ..........
   4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт ..........
   4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..........
   4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..........
   4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ..........
5. Аудитын илрүүлэлт ..........
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл ..........


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |
| Аймгийн ИТХ | Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал |
| ХХАА | Хүнс, хөдөө аж ахуй |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

Төсвийн захирагч

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

ӨЛГИЙ СУМЫН ЗДТГ-ЫН
ДАРГА С. ЖАДЫРА ТАНАА

2024.02.13 № 78

танай ____________-ны № ____________-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өлгий сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өлгий сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, заавар дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлантай холбоотой онцлох асуудал гараагүй

**Аудитын гол асуудал**

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 1,640.6 сая төгрөгийн авто зам, аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн 69.6 сая төгрөгийн гүүр, 20.0 сая төгрөгийн авто зогсоолыг орлого авч данс бүртгэлд тусгасан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд

00402100

хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.АЙГҮЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **16,262,177.00** | **27,908,552.00** |
| **33** | **АВЛАГА** | 5,050,777.00 | 1,197,152.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 3,120,777.00 | 1,197,152.00 |
| **335** | **Бусад авлага** | 1,930,000.00 | - |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 1,930,000.00 | - |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 11,211,400.00 | 26,711,400.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 11,211,400.00 | 26,711,400.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 414,100.00 | 414,100.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 5,744,820.00 | 21,244,820.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 5,052,480.00 | 5,052,480.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **13,735,545,606.85** | **14,630,279,869.35** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 13,735,545,606.85 | 14,630,279,869.35 |
| **392** | **Биет хөрөнгө** | 13,712,156,606.85 | 14,605,467,630.35 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,224,359,764.00 | 1,224,359,764.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (179,820,394.21) | (224,753,117.14) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 130,409,999.00 | 70,719,999.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (73,969,166.74) | (19,330,416.74) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 111,012,659.00 | 122,567,659.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (58,973,296.08) | (72,369,025.69) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 97,374,635.00 | 97,624,635.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (63,201,361.05) | (70,418,579.27) |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 13,365,425,036.00 | 15,095,736,372.00 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | (1,028,109,618.12) | (1,799,191,831.71) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 315,151,833.00 | 315,151,833.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (127,503,482.95) | (150,629,661.10) |
| 39217 | Ном | - | 16,000,000.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 23,389,000.00 | 24,812,239.00 |
| 39301 | Програм хангамж | 550,000.00 | 1,973,239.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (550,000.00) | (550,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 23,389,000.00 | 23,389,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **13,751,807,783.85** | **14,658,188,421.35** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **13,751,807,783.85** | **14,658,188,421.35** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 13,751,807,783.85 | 14,658,188,421.35 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 143,765,376.00 | 143,765,376.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 143,765,376.00 | 143,765,376.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 13,410,555,933.09 | 14,316,936,570.59 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 14,488,422,947.64 | 13,410,555,933.09 |

| | | | |
|---|---|---|---|
| 51220 | Тайлант үеийн үр дүн | (1,077,867,014.55) | 906,380,637.50 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 197,486,474.76 | 197,486,474.76 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **13,751,807,783.85** | **14,658,188,421.35** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,005,352,250.00** | **3,025,920,406.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **-** | **1,768,955,575.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | - | 1,768,955,575.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | - | 1,753,455,575.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал | - | 15,500,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,005,352,250.00** | **1,256,964,831.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 61,500,000.00 | - |
| 131005 | Хөрөнгийн санхүүжилт | 61,500,000.00 | |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 12,926,350.00 | 15,704,931.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,210,000.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,200,000.00 | 15,704,931.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 4,516,350.00 | - |
| 131106 | Төсвийн урамшуулал | - | - |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 930,925,900.00 | 1,241,259,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 923,403,800.00 | 1,241,259,900.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 7,522,100.00 | - |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **2,083,219,264.55** | **2,119,539,768.50** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,083,219,264.55** | **2,119,539,768.50** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,012,217,259.55 | 2,098,968,158.50 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 586,406,578.00 | 907,189,425.00 |
| 210101 | Үндсэн цалин | 419,686,344.00 | 596,444,679.18 |
| 210102 | Нэмэгдэл | 112,471,900.00 | 276,046,066.82 |
| 210104 | Урамшуулал | - | 34,698,679.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 54,248,334.00 | - |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 73,534,800.00 | 113,158,200.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 48,125,300.00 | 76,947,600.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 12,673,300.00 | 9,052,700.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,396,300.00 | 7,242,100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 849,100.00 | 1,810,500.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,490,800.00 | 18,105,300.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 41,852,698.00 | 48,989,400.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,453,854.00 | 7,651,246.00 |
| 210302 | Түлш, халаалт | 35,339,797.00 | 38,441,464.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,059,047.00 | 2,896,690.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 46,071,431.00 | 45,002,931.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,821,700.00 | 6,801,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 34,502,300.00 | 32,038,331.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 5,577,431.00 | 5,827,600.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 170,000.00 | 336,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 1,191,900.00 | 1,140,100.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,191,900.00 | 1,140,100.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,850,910.00 | 2,655,600.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 478,400.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 1,332,200.00 | 1,077,100.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,518,710.00 | 1,100,100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 4,198,000.00 | 11,579,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,198,000.00 | 11,579,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,400,220.00 | 22,893,218.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 880,290.00 | 20,995,600.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 462,200.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 90,500.00 | 230,018.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 183,100.00 | 399,800.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 141,300.00 | 348,400.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 559,900.00 | 788,300.00 |
| 210807 | Газрын төлбөр | 74,430.00 | 131,100.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 8,500.00 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,251,710,722.55 | 946,360,284.50 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 99,318,686.00 | 81,979,518.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 337,600.00 | 710,454.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 1,152,054,436.55 | 863,670,312.50 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 71,002,005.00 | 20,571,610.00 |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | 7,522,100.00 | - |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 7,522,100.00 | - |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 52,761,500.00 | 13,999,300.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 23,746,700.00 | - |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 29,014,800.00 | 9,209,300.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 4,790,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 10,718,405.00 | 6,572,310.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 10,718,405.00 | 6,572,310.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(1,077,867,014.55)** | **906,380,637.50** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(1,077,867,014.55)** | **906,380,637.50** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **943,852,250.00** | **1,256,964,831.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **943,852,250.00** | **1,256,964,831.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 12,926,350.00 | 15,704,931.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,210,000.00 | |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,200,000.00 | 15,704,931.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 4,516,350.00 | |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 930,925,900.00 | 1,241,259,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 923,403,800.00 | 1,241,259,900.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 7,522,100.00 | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **940,972,250.00** | **1,252,015,831.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **940,972,250.00** | **1,252,015,831.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **869,970,245.00** | **1,231,444,221.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 593,834,100.00 | 905,265,800.00 |
| 210101 | Үндсэн цалин | 420,153,600.00 | 594,521,054.18 |
| 210102 | Нэмэгдэл | 112,471,900.00 | 276,046,066.82 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 34,698,679.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 61,208,600.00 | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 73,534,800.00 | 113,158,200.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 48,125,300.00 | 76,947,600.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 12,673,300.00 | 9,052,700.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,396,300.00 | 7,242,100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 849,100.00 | 1,810,500.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,490,800.00 | 18,105,300.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 41,949,996.00 | 48,989,400.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,551,152.00 | 7,200,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 35,787,100.00 | 38,537,300.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,611,744.00 | 3,252,100.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 43,316,533.00 | 45,002,931.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,830,900.00 | 6,801,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 31,866,800.00 | 32,038,331.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 5,530,133.00 | 5,827,600.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 88,700.00 | 336,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 1,194,200.00 | 1,140,100.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,194,200.00 | 1,140,100.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,879,200.00 | 2,655,600.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | 478,400.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 1,479,200.00 | 1,077,100.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,400,000.00 | 1,100,100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 4,198,000.00 | 11,579,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,198,000.00 | 11,579,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,346,730.00 | 22,893,218.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 826,800.00 | 20,995,600.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 462,200.00 | |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 90,500.00 | 230,018.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 183,100.00 | 399,800.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 141,300.00 | 348,400.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 559,900.00 | 788,300.00 |
| 210807 | Газрын төлбөр | 74,430.00 | 131,100.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 8,500.00 | |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 104,716,686.00 | 80,759,972.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 104,379,086.00 | 80,049,518.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 337,600.00 | 710,454.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **71,002,005.00** | **20,571,610.00** |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | 7,522,100.00 | - |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 7,522,100.00 | |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 52,761,500.00 | 13,999,300.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 23,746,700.00 | |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 29,014,800.00 | 9,209,300.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 4,790,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 10,718,405.00 | 6,572,310.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 10,718,405.00 | 6,572,310.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **2,880,000.00** | **4,949,000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **4,680,000.00** | **4,949,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **4,680,000.00** | **4,949,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 4,680,000.00 | 4,949,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 4,680,000.00 | 4,949,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(4,680,000.00)** | **(4,949,000.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | (1,800,000.00) | - |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 137,765,376.00 | 197,486,474.76 | 14,488,422,947.64 | | 14,823,674,798.40 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | | 0.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **137,765,376.00** | **197,486,474.76** | **14,488,422,947.64** | **0.00** | 14,823,674,798.40 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | | | | 0.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний  бууралт | 6,000,000.00 | | | | 6,000,000.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | | 0.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | -1,077,867,014.55 | | -1,077,867,014.55 |
| C08 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **143,765,376.00** | **197,486,474.76** | **13,410,555,933.09** | **0.00** | 13,751,807,783.85 |
| D01 | **2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **143,765,376.00** | **197,486,474.76** | **13,410,555,933.09** | **0.00** | 13,751,807,783.85 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | | 0.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **143,765,376.00** | **197,486,474.76** | **13,410,555,933.09** | **0.00** | 13,751,807,783.85 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт,  бууралт | | | | | 0.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | | | 0.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | | 0.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | | 0.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | 906,380,637.50 | | 906,380,637.50 |
| D09 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **143,765,376.00** | **197,486,474.76** | **14,316,936,570.59** | **0.00** | 14,658,188,421.35 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,241,259,900.00 | 1,235,187,590.00 | 6,072,310.00 | 99.5 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,241,259,900.00 | 1,235,187,590.00 | 6,072,310.00 | 99.5 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,227,192,600.00 | 1,221,188,290.00 | 6,004,310.00 | 99.5 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 905,265,800.00 | 905,265,800.00 | - | 100.0 |
| 210101 | Үндсэн цалин | 600,638,600.00 | 600,638,600.00 | - | 100.0 |
| 210102 | Нэмэгдэл | 304,627,200.00 | 304,627,200.00 | - | 100.0 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 113,158,200.00 | 113,158,200.00 | - | 100.0 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 76,947,600.00 | 76,947,600.00 | - | 100.0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 9,052,700.00 | 9,052,700.00 | - | 100.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,242,100.00 | 7,242,100.00 | - | 100.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,810,500.00 | 1,810,500.00 | - | 100.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 18,105,300.00 | 18,105,300.00 | - | 100.0 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 48,989,400.00 | 48,989,400.00 | - | 100.0 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,200,000.00 | 7,200,000.00 | - | 100.0 |
| 210302 | Түлш, халаалт | 38,537,300.00 | 38,537,300.00 | - | 100.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,252,100.00 | 3,252,100.00 | - | 100.0 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 44,182,500.00 | 44,182,500.00 | - | 100.0 |
| 210401 | Бичиг хэрэг | 7,600,000.00 | 7,600,000.00 | - | 100.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 30,418,900.00 | 30,418,900.00 | - | 100.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 5,827,600.00 | 5,827,600.00 | - | 100.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 336,000.00 | 336,000.00 | - | 100.0 |
| **2105** | **Нормативт зардал** | 1,190,100.00 | 1,140,100.00 | 50,000.00 | 95.8 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,190,100.00 | 1,140,100.00 | 50,000.00 | 95.8 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,895,200.00 | 2,655,600.00 | 239,600.00 | 91.7 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 718,000.00 | 478,400.00 | 239,600.00 | 66.6 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 1,077,100.00 | 1,077,100.00 | - | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 1,100,100.00 | 1,100,100.00 | - | 100.0 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 11,968,000.00 | 11,579,000.00 | 389,000.00 | 96.7 |
| 210702 | Дотоод албан томилолт | 11,968,000.00 | 11,579,000.00 | 389,000.00 | 96.7 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 31,848,600.00 | 26,593,218.00 | 5,255,382.00 | 83.5 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр | 29,595,600.00 | 24,695,600.00 | 4,900,000.00 | 83.4 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 295,000.00 | | 295,000.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 290,400.00 | 230,018.00 | 60,382.00 | 79.2 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 399,800.00 | 399,800.00 | - | 100.0 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 348,400.00 | 348,400.00 | - | 100.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 788,300.00 | 788,300.00 | - | 100.0 |
| 210807 | Газрын төлбөр | 131,100.00 | 131,100.00 | - | 100.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 67,694,800.00 | 67,624,472.00 | 70,328.00 | 99.9 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 66,976,800.00 | 66,914,018.00 | 62,782.00 | 99.9 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 718,000.00 | 710,454.00 | 7,546.00 | 98.9 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 14,067,300.00 | 13,999,300.00 | 68,000.00 | 99.5 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 14,067,300.00 | 13,999,300.00 | 68,000.00 | 99.5 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 9,209,300.00 | 9,209,300.00 | - | 100.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,858,000.00 | 4,790,000.00 | 68,000.00 | 98.6 |
| **13** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,241,259,900.00 | 1,235,187,590.00 | 6,072,310.00 | 99.5 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,241,259,900.00 | 1,235,187,590.00 | 6,072,310.00 | 99.5 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 1,241,259,900.00 | 1,235,187,590.00 | 6,072,310.00 | 99.5 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1 | 1 | - | |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 | - | |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 62 | 57 | 5.00 | 91.9 |
| 620001 | Удирдах ажилтан | 17 | 14 | 3.00 | 82.4 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 33 | 21 | 12.00 | 63.6 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 8 | 16 | (8.00) | 200.0 |
| 620004 | Гэрээт ажилтан | 4 | 6 | (2.00) | 150.0 |
| | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **62** | **57** | 5.00 | 91.9 |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 35 | 21 | 14.00 | 60.0 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 8 | 16 | (8.00) | 200.0 |
| 650010 | Гэрээт ажилтан | 4 | 6 | (2.00) | 150.0 |
| 650011 | Улс төрийн албан хаагч (УТ) | 15 | 14 | 1.00 | 93.3 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **15,204,931.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **15,204,931.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 15,204,931.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 1,619,431.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,619,431.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 13,585,500.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 13,585,500.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 15,704,931.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 15,704,931.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 15,704,931.00 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

***Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар:***

Өлгий сумын Засаг даргын Тамгын газрын чиг үүрэг нь Засгийн газрын бодлого шийдвэрийг сурталчлах, хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах, төрийн хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжүүлэх, сумын хүн ам, ХХАА-н үйлдвэрлэл, үйлчилгээний бүртгэл судалгааг хөтөлж, дээд шатны байгууллагыг мэдээ мэдээллээр хангах, сумын хөгжлийн хөтөлбөр, Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллахад оршино.

Өлгий сумын Засаг даргын Тамгын газрын зорилго нь “Төрийн бодлого боловсруулах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, төрийн үйлчилгээг ард иргэдэд хүртээмжтэй хүргэх, элдэг хамт олон байх төрийн үйлчилгээг нээлттэй, шуурхай хүргэх”

Дээрх зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.

- Төр засгийн бодлогыг орон нутгийн онцлогт уялдуулан хэрэгжүүлэх,
- Аймгийн дэвшүүлсэн зорилго, зорилтыг орон нутгийн онцлогт тохируулан хэрэгжүүлэх,
- Сумын Засаг даргын үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, явуулах ажлын чиглэл тодорхойлох,
- Сумын Засаг даргыг мэдээллээр хангах,
- Ард иргэдийн өргөдөл гомдол, санал санаачлалыг дэмжих шийдвэрлэх,
- Ард иргэдэд түргэн шуурхай үйлчлэх,
- Ард иргэдийн тав тухтай аюулгүй орчинд амьдрах нөхцөл боломжоор хангах

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

*Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар*

Өлгий сумын Засаг даргын Тамгын газар нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын багц хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн болон олон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон олон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзэв.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сангийн сайдын 2023 оны 65 дугаар “Хөтөлбөр батлах тухай” тушаалаар аккруэл суурьт УСНББОУС-ыг нэвтрүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг баталсан байна.

Өлгий сумын Засаг даргын Тамгын газрын  2023  оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

***Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар***

Өлгий сумын Засаг даргын Тамгын газар нь 2020 онд баталсан ”Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдлөг болгон ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Өлгий сумын Засаг даргын Тамгын газрын  2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 906.3 сая төгрөгөөр буюу 6.6 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | | | |
| Авлага | 5,050.8 | 1,197.2 | (3853.6) |
| Бараа материал | 11,211.4 | 26,711.4 | 15,000.0 |
| Үндсэн хөрөнгө | 13,735,545.6 | 14,630,279.9 | 854,734.3 |
| **Нийт хөрөнгө** | **13,751,807.8** | **14,658,188.4** | **906,380.6** |
| Өр төлбөр | | | |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 13,751,807.8 | 14,658,188.4 | 906,380.6 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **13,751,807.8** | **14,658,188.4** | **906,380.6** |

Дансны авлага 1.2 сая төгрөг болж 3.8 сая төгрөгөөр буурсан нь ажиллагсадтай холбоотой авлагыг барагдуулсантай  холбоотой байна.

Бараа материалын данс 15.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь гамшгаас хамгаалах сангийн хөрөнгөөр  нийлүүлсэн 11.0 сая төгрөгийн иж бүрэн хувцас, сумын ОНХС-аас нийлүүлсэн 4.5 сая төгрөгийн аюулгүйн цэгийн байршилд байршуулсан самбаруудыг орлого авсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс 854.7 сая төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр худалдан авсан 4.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 1,640.6 сая төгрөгийн авто зам, аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн 69.6 сая төгрөгийн гүүр, 20.0 сая төгрөгийн авто зогсоол, сумын ОНХС-ийн хөрөнгөөр нийлүүлсэн 15.7 сая төгрөгийн ном, аймгийн Засаг даргын дэмжлэгээр нийлүүлсэн 5.7 сая төгрөгийн компьютер, сумын ИТХ-аас нийлүүлсэн 2.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгөөр нэмэгдэж, аймгийн ИТХ-ын 2022 оны 117 дугаар тогтоолоор 34.7 сая төгрөгийн 2 авто машиныг акталсан, 2023 оны 149 тогтоолоор 25.0 сая төгрөгийн авто машиныг балансаас балансt шилжүүлсэн үндсэн хөрөнгө болон тайлант оны элэгдлийн зардал хасагдсантай холбоотой байна.

Тайлант оны үр дүнгээр Засгийн газрын хувь оролцоо данс 906.4 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,559.1 сая төгрөг, нийт зарлагыг 1,559.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 473.3 сая төгрөгөөр бууруулж, 1085.8 сая төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 1 удаа төсвийн тодотгол хийгдэж нийт дүнгээр 155.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж 1,241.3 сая төгрөгөөр баталсан байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 6 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,241.3 сая төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,241.3 сая төгрөгийн санхүүжилт олгож, 6.0 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,235.2 сая төгрөг буюу 99.5 хувьтай байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 70106 | ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага | **1,241,259.9** | **1,235,187.6** | **6,072.3** | **99.5%** |
| 80101 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 668,147.7 | 667,147.7 | 1,070.2 | 99.8% |
| 80102 | Туслах үйл ажиллагааны зардал | 471,544.9 | 471,544.9 | 0 | 100% |
| 80802 | Ажил олгогчоос олгох тэтгэмж | 14,067.3 | 13,999.3 | 68.0 | 99.5% |
| 81102 | Орон нутгийн нөөц хөрөнгө | 60,000.0 | 59,965.9 | 34.1 | 99.9% |
| 81701 | Байгаль орчныг хамгаалах | 22,500.0 | 19,250.0 | 3,250.0 | 85.5% |
| 82212 | Хог хаягдал,орчны бохирдол | 5,000,0 | 3,350.0 | 1.650.0 | 67% |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Өлгий сумын Засаг даргын Тамгын газрын  нэмэлт дансанд Статистикийн хэлтсээс 7.3 сая, аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсээс 3.5 сая, аймгийн ИТХ-аас 4.2 сая, бусад орлогоор 0.7 сая төгрөгийн нийт 15.7 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч аймгийн Санхүү, төрийн сангаас нээсэн эрхийн дагуу тээвэр шатахуунд 1.6 сая, бараа үйлчилгээний зардалд 13.6 сая төгрөгийг зарцуулж 0.5 сая төгрөгийг төвлөрүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### *3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн*

Өлгий сумын Засаг даргын Тамгын газар 2023 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Өлгий сумын Засаг даргын Тамгын газар нь 2023 онд батлагдсан төсвийн хүрээнд 49.0 сая төгрөгийн бараа материал, 4.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу аймгийн Өлгий сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай  холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор У.Ербол гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Өлгий сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 2/48 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Өлгий сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагын 2,083.2 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 23.4 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжилтийг шалгаж үзэхэд бараа, үйлчилгээний бусад зардлаас жилийн эцэст 8,604.0 мянган төгрөгийн бэлэг дурсгал, шагнал олгосон байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага өгөв.

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 1,214.3 сая төгрөгийн 53 мөнгөн гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 53.9 сая төгрөгийн 7 мөнгөн гүйлгээг байршуулахаас, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээнээс 1,214.3 сая төгрөгийн 53 мөнгөн гүйлгээг мэдээлээгүй байна. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 75 хувьтай буюу өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлэв.

**4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Бусад хууль тогтоомжийн хүрээнд алдаа, зөрчилтэй асуудал гараагүй болно.

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

**4.5.1 Завсрын аудитын талаар**

Өлгий сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайланд завсрын аудитын хийгдэж, аудитаар илэрсэн зөрчлийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянаж үр дүнг аудитын тайланд тусгав.

**4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтийг давтан шалгаж үзэхэд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчилд 13,179.5 мянган

төгрөгийн албан шаардлага өгсөн ба хэрэгжилт 68.5 хувьтай, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 21,300.0 мянган төгрөгийн зөрчилд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Албан шаардлага | 2 | 41,937.1 | 1 | 28,757.6 | 68.5% |
| Зөвлөмж | 1 | 21,300.0 | | | 0% |
| **Нийт дүн** | **2** | **63,237.1** | **1** | **28,757.6** | 68.5% |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитаар цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан эрсдэлтэй гэж сонгосон дансуудад горим сорил хэрэгжүүлж, төсвийн зарцуулалтыг түүвэрлэн шалгасан тул төсвийн зарцуулалтын гүйцэтгэлийн шалгалтаар дэлгэрэнгүй шалгах шаардлагатай.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 17,365.0 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 17,365.0 мянган төгрөгийн алдааг залруулав. Үүнд:

Санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалыг 17,365.0 мянган төгрөгөөр алдаатай тусгасныг залруулав.

Аудитаар нийт 49,551.8 мянган төгрөгийн зөрчил[1] илэрснээс, 739.6 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 8,604.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 81,610.7 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

Аудитаар нийт 739.6 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоов.Үүнд:

1. Засаг даргын Тамгын газрын Санхүү, албаны даргын албан тушаалтан эрхэлдэг албан хаагчид сумын Засаг даргын 2021 оны Б/12 дугаар захирамжаар Улаан загалмайн нийгэмлэгийн ажлыг хавсран гүйцэтгэсний 40 хувь нэмэгдэл олгох шийдвэрийн дагуу 2023 оны 1-2 дугаар сард нийт 739.6 мянган төгрөг олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т *“төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д *"батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах",* 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсгийн 41.2.3-т *“төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”* гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хууль тогтоомж зөрчин олгосон 739.6 мянган төгрөгийн цалингийн нэмэгдлийг нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**5.2 Албан шаардлага**

Аудитаар 8,604.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага өгөв.

1.Шилэн дансны мэдээллээс цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 1,214.3 сая төгрөгийн 53 мөнгөн гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 53.9 сая төгрөгийн 7 мөнгөн гүйлгээг байршуулахаас, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээнээс 1,214.3 сая төгрөгийн 53 мөнгөн гүйлгээг мэдээлээгүй байна. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 75 хувьтай буюу өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.4-т ”Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, 6 дугаар зүйлийн 6.4.5- т” цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”,Засгийн газрын 2019 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын холбогдох заалтуудыг тус тус зөрчсөн, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй тул зөрчил арилгах албан шаардлага хүргүүлэв.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлэв.

**5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**1. Зардлын данстай холбоотой асуудал**

*1.1 Илрүүлэлт:*

Төрийн захиргааны албан тушаал эрхэлдэг албан хаагчдад 30 хувиар тооцож, нийт 68,462.7 мянган төгрөгийн орон нутгийн нэмэгдлийг тушаал, шийдвэргүй олгосон нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5-т “Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын тамгын газрын дарга, Засаг даргын дэргэдэх газар, хэлтэс, албаны дарга эрх хэмжээнийхээ хүрээнд тушаал гаргаж, тогтоосон журмаар үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

*1.2 Өгсөн зөвлөмж*:

Төрийн захиргааны албан тушаал эрхэлдэг албан хаагчдад орон нутгийн нэмэгдлийг тушаал, шийдвэрийн дагуу олгож хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах.

*2.1 Илрүүлэлт:*

Сумын Засаг даргад 4,077.5 мянган төгрөгийн албан томилолтын зардлыг бүрдэл дутуу баримтаар олгосон нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13 дугаар зүйлийн 7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

*2.2 Өгсөн зөвлөмж*: Бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийхгүй байх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах

*3.1 Илрүүлэлт:*

Цалингийн зардлаас 6,720.0 мянган төгрөгийг нүүрсний хөнгөлөлтөд, албан томилолтын зардлаас 2,350.5 мянган төгрөгийг хувь хүний орлогын албан татварт нийт 9,070.5 мянган төгрөгийг зөвшөөрөлгүй шилжүүлсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах",16 дугаар зүйлийн 16.5.5-т "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалын хавсралтаар баталсан "зардлын эдийн засгийн ангилал, ашиглах заавар"-ыг зөрчсөн байна.

*3.2 Өгсөн зөвлөмж*:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан журмын дагуу зардлын эдийн засгийн ангиллыг мөрдөж, батлагдсан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байдлаар төлөвлөж, зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| СҮДТ-д үнэ төлбөргүй авсан бараа материалыг алдаатай тайлагнасан | 1 | 17,365.0 | | | 1 | 17,365.0 | | | | | | |
| **Дүн** | 1 | 17,365.0 | | | 1 | 17,365.0 | | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | Үүнээс | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Төлбөрийн акт | Албан шаардлага | Зөвлөмж | Хариуцлага тооцуулах албан шаардлага | Хууль, хяналтын байгууллагад |

# Өлгий сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| | | | | | | | | | | | шилжүүлсэн асуудал | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | То о | Дүн | Т о о | Дүн | То о | Дүн | Т о о | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Хууль тогтоомж зөрчин илүү олгосон цалингийн нэмэгдэл | 1 | 739.6 | 1 | 739.6 | | | | | | | | |
| Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж шагнал олгосон | 1 | 8,604.0 | | | 1 | 8,604.0 | | | | | | |
| Орон нутгийн нэмэгдлийг тушаал, шийдвэргүй олгосон | 1 | 68,462.7 | | | | | 1 | 68,462.7 | | | | |
| Зардал хооронд зөвшөөрөлгүй шилжүүлсэн | 1 | 9,070.5 | | | | | 1 | 9,070.5 | | | | |
| Бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийсэн | 1 | 4,077.5 | | | | | 1 | 4,077.5 | | | | |
| **Дүн** | **5** | **90,954.3** | **1** | **739.6** | **1** | **8,604.0** | **3** | **81,610.7** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүх мөнгөн гүйлгээг мэдээлээгүй | 1 | 1,214,442.4 | | | 1 | 1,214,442.4 | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Нийт дүн | | | | | | | | |